

# ТАХИЙН МЭДЭЭ



№. 5 | 2016 оны 11-р сар

## ИРЭЭДҮЙ РҮҮ АЛХАМ АЛХМААР

Алдарт “Цуут” нэртэй тахийн унага 2015 оны намар сүргээсээ төөрч гэрийн адуутай нийлсэн байсныг тахь хамгаалагч нар олж аван тахь нутагшуулах төвийн дасгах хашаанд шинээр тээвэрлэн авчирсан гүүнүүдтэй хамт өвөлжүүлсэн юм. Хавар нь Цуут даагыг дассан гүүнүүдийн хамт задгай бэлчээрт гаргасан бөгөөд одоо тахийн залуу сайхан үрээ болсон юм.



## Тахь болон түүний амьдрах орчныг хамтдаа хамгаалцгаая

## Тахийг хайрлан хамгаалдаг эрхэм андууд аа!



Тал нутагт амьдардаг ард түмэн нүүж амьдрахаас өөр аргагүй юм. Учир нь ус рашаан, хур бороо, өвс ургамал улирлын шинжтэй. Амьтад энэхүү тогтолцоо, нөөцөд тулгуурлан амьдардаг нь эртнээс тогтсон зохилдолгоо бөгөөд цаашид ч ийм байх учиртай. Тиймээс тал нутгийн амьтад урт хугацаанд оршин

тогтнохын тулд хамгаалалттай газраас ч том газар нутаг шаардлагатай болдог ба энэ нь улирлын шинжтэй гарч ирэх саад бэрхшээлийг даван туулах орчныг бүрдүүлж өгдөг. Төмөр зам, авто зам, шинэ хот суурин болон зүгээр нэг жижиг малын хашаа ч шилжилт хөдөлгөөнд саад учруулж болох юм. Ийм ч учраас байгаль хамгаалагч бид саад учруулж буй зүйлсийг олж илрүүлэх, арилгах арга замыг газар нутгийн хувьд төдийгүй оюун бодолдоо хайх үүрэгтэй. Олон улсын тахь групп олон саад бэрхшээлийг сөрөн тахийг (*Equus przewalskii*) устаж үгүй болохоос нь өмнө, цөөн үлдсэн

тахийн амьдрах орчныг хамгаалах, сэргээн нутагшуулах ажлыг хийж чадсан юм.

Гэвч бид энэхүү өөрсдийн амжилтанд сэтгэл ханаад сууж таарахгүй. Говь, тал нутгийн өвөрмөц онцлог, өвс ургамал, амьтны аймаг, тэдний амьдрах орчныг хамгаалах, цаашлаад хойч үедээ өвлүүлэн үлдээхийн тулд хил хязгаараар зааглагдахгүй хамтран ажиллах, туслах байгууллага, холбоодыг хайх ажилдаа идэвхтэй байж, илүү бүтээмжтэй хичээн ажиллах шаардлагатай байна. Мэдээж тахийн сүргийг хамгаалах нь бидний гол зорилго боловч байгалийн үнэлж баршгүй өвийг алдагдуулахгүйн тулд тахийн амьдрах орчныг хамгаалах, зэрлэг амьтдын нүүдэллэдэг зам, жимийг хэвээр байлгахад анхаарлаа хандуулан ажиллаж ирлээ. Энэхүү ажлаа үргэлжлүүхэд бидэнд та болон тань шиг сайхан сэтгэлтэй дэмжигч нар их урам өгч байна. Та бидэнтэй хамт байгаарай.

*(Signature)*

Д-р. Райнхард Шнидрих,  
Олон Улсын Тахь Группын ерөнхийлөгч



Энэ жил бид Зүүнгарын говьд хоёр удаагийн тээвэрлэлтээр найман тахь авчирсан. Зурган дээр эхний тээвэрлэлт хийж буй нь. Ачааны машинаар хайрцаганд хийсэн тахиудыг хоёр хоёроор тээвэрлэдэг. Говийн Их Дархан Цаазат Газар (ГИДЦГ)-ын Энэ жил "Б" бүсэд байгаа говьд хоёр удаагийн тээвэрлэлтээр хамгаалах ажиллагаа явагчид, Валентин болон Хайтээвэрлэлт Агаарын нь. Ачаа тээврийн хэрэгсэлд хийсэн дагуу хувийн ажиллагааг зохиож буй нь. Үүгээр илэрхийлэхэд цаазат газар ГИДЦГ-ийн "Б" бүсэд байгаа амьдрах адал явдал тэдний хувьд эхэлж байна. Тэхийн тухай бид бэлтгэсэн сонирхолтой нийтлэлийг унших болромжтой. Зураг: Ваклав Сиджа

## Прагаас Говьд: Тахийг зургаа дах удаагаа тээвэрлэн авчирлаа

Прагийн амьтны хүрээлэн нь Олон улсын тахь группын гишүүн бөгөөд дэлхий дээрх тахийн удмын бичгийг хөтлөх хариуцлагатай ажлыг эрхэлдэг. Мөн ГИДЦГ-ын “Б” хэсгийн хамгаалалтын захиргааны үйл ажиллагааг дэмждэг гол хандивлагч байгууллага юм. Захирал д-р Мирослав Бобэк нь Олон улсын тахь группын үйл ажиллагааг дэмжихэд зориулан Чехийн хөгжил хамтын ажиллагааны тусламжийг аваад зогсохгүй Чехийн цэргийн нисэх хүчний онгоцоор Монгол улс руу тахь тээвэрлэх боломжийг бий болгож чадсан юм. Энэ нь нэг талаар цэргийн бэлтгэл хийх нислэг боловч Олон улсын тахь группэд үнэ төлбөргүй хийж өгч буй ажил юм. Энэ нислэг нь д-р Бобэкийн нийтлэлт гардаг шиг адал явдалтай боловч зохион байгуулалт болоод захиргааны маш их хүчин чармайлт шаардсан ажил юм.

*Д-р Мирослав Бобэк, Прагийн амьтны хүрээлэнгийн захирал. Зураг: Ваклав Силха*

Тахийг тээвэрлэх ажил тогтмол хийгддэг, стандартчлагдсан үйл явц мэт харагдаж болох юм. Гэвч тахийг Монгол улс руу хэдий чинээ их тээвэрлэнэ төдий чинээ бидний сэтгэл түгшиж байдаг. Татлага нэг өдөр тасрахыг үгүйсгэхгүй. Тахьтай хайрцгийг нутагшуулах хашаанд аваачихаас нааш баталгаа өгөх аргагүй юм. Хийгдэж буй ажил бүр их ач холбогдолтой бөгөөд ажлыг гүйцэтгэж буй хүмүүсээс маш их хичээл зүтгэл шаарддаг.

Энэ нь Чехээс Монголын говьруу тахь тээвэрлэх ч бай монголын дотоодод тээвэрлэлт хийхээр төлөвлөсөн байсан ч ялгаагүй.

### Хустайн нурууны БЦГ-т хийгдэх бэлтгэл ажил

Аль хэдийнээ 5-р сарын эх болсон байтал Хустай нуруунд цасан шуурга болж тахь дасгах хашааны материал ачсан машин хүрэх газартаа очиж чадахгүй байсан нь намайг тийм ч их цочролд оруулаагүй бөгөөд Монголын нөхдүүд маань энэ ажлыг төвөггүйхэн амжуулж чадна гэдэгт итгэлтэй байсан юм.

Улаанбаатар хотоос цаг гаран давхиад очих Хустайн нуруунд 350 тахь байдаг. Эхлээд Европоос, дараа нь Монгол улс дотор хийх хоёр тээвэрлэлтийг хослуулан хийх санааг монгол талын түншүүдтэй дөрвөн жилийн өмнөөс хийхээр төлөвлөн ярилцаж байсан ба үүнийг хэрэгжүүлэхэд багагүй олон саад бэрхшээл тохиолдож байв.

Бид Монголын хэд хэдэн сайдтай уулзан тохиролцож ажлаа алхам алхмаар явуулж, тээвэрлэлтийн асуудлыг шийдвэрлэснээр Хустайн нуруунд хашаа барьж, Говийн “Б” бүс рүү тээвэрлэх тахиудыг барих ажлыг эхлүүлсэн. Энэ ажилтай холбогдолтой материал бараг нэг ном болохоор байна.

Роман Водика болон Жим Расмуссэн малын эмч нарын идэвхи зүтгэл, амжилттай ажиллагааны үр дүнд 5-р сарын 20- доор Хустайн нуруунд барьсан хашаанд 7 тахийг хашиж чадсан ба үүнтэй зэрэгцээд Чех улсад Монголруу ачигдах тахийн бэлтгэлийг мөн сайн хийж чадсан юм.



*Д-р Бобэк болон байгаль хамгаалагч Б.Батсуурь нар Рэвэта гүүг тахийн талд сул тавьж буй нь. Машины гэрэл бидэнд хангалттай байлаа.*

### Цагдаагийн хамгаалалттай

Бид Прагаас 100 км-д байрлах “Долны Добрэжов” тахь үржүүлгийн газраас өмнөх жилүүдийнхтэй адил аялалаа эхлүүлсэн юм. Европт байрлах үржүүлгийн нэлээд хэдэн газраас цуглуулсан 7 гүү манай үржүүлэх төвд байрлаж байлаа.

7-р сарын 16-ны өдөр буюу Бямба гаригийн 7 цаг өнгөрөөгөөд тахь ачих ажил эхлэсэн юм. Нара, Хайа, Рэвэта болон Хайлигэ нэртэй тахиудыг дараалуулан тээвэрлэх хайрцганд оруулах явц бас тийм ч амар байсангүй. Рэвэта мэдээ алдуулалтын хугацаанаас түрүүлж сэрснээс болж асуудал гарч болох байсан ч азаар тийм юм болсонгүй.

Автозамын түгжрэл, ачааллаас үүдэн хоцрохоос сэргийлэн онгоцны буудал хүрэх замыг түр хугацаагаар хааж ба тахь ачсан машинуудыг цагдаагийн хамгаалалт хөтөлж явсан юм. Ингэснээр “Долны Добрэжов” -оос онгоцны буудалруу маш богино хугацаанд очсон юм.

Прагийн амьтны хүрээлэнгийн логотой машиныг цагдаагийн хамгаалалтын машин хамгаалж явсан нь бусдын анхаарлыг ихэд татсан ба маш ховор амьтан магадгүй Пандаг Прагийн амьтны хүрээлэнд авчирч байж болох юм гэсэн цуурхал маш хурдан тархсан байлаа.

### Праг – Казань – Новосибирск – Булган сум

Бүхээгт тахь болон малын эмч, тээвэрлэлтийн багийн хүмүүсийг суулгасан Каса цэргийн онгоц Кбэли онгоцны буудлаас 14:10 минутад хөөрлөө. ОХУ-ын Казань хотын нисэх буудалд түр зогсолт хийхэд бүх зүйлс хэвийн байлаа. Казань дах хил гаалийн ажилтнуудын хүнд суртлаас болон бид нэлээн хоцорсон юм. Энэ хүртэл бид минут бүрийг хожих гэж зүтгэж байсан бол Казанд цаг урссаар байлаа. Гүүнүүд эдгээр саад бэрхшээлийг азаар даван туулж, Говьд харанхуй болсон ч хамаагүй хүргэн суллаж чадна хэмээн бид найдах үл дэж байв.

Новосибирск-д хийсэн хоёрдох зогсолтонд хүчтэй салхи шуургатай байсан тул бид дахин хүлээх болсон юм. Гэвч энэнээс өөр гомдоллоод байх зүйл гарсангүй. Харин Булган орох замд салхины эрч зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрч байсан тул бид бараг л бууж чадахгүйд хүрэх байлаа. Каса онгоц маань хазайж буухад хүндрэлтэй байсан ч задгай талбайд бид зөөлөн газардсан юм. Энэ нь 7-р сарын 17-ны өдөр байсан ба европын цагаар 10:35 минут, харин орон нутгийн цагаар 17:35 болж байв. Чехийн цэргийн онгоцоор ийнхүү Монголд аюулгүй хүргэгдэж ирсэн тахийн тоог 23 болгосон юм.

ГИДЦГ-ын “Б” хэсгийн хамт олон болон бусад ажилчид нар биднийг угтан авсан юм. Бид хурдан гэгч нь тахьтай хайрцагаа буулган, Тахийн талруу ачааны машинаар тээвэрлэлээ. Шөнө дундаас хагас цаг өнгөрсөн байхад бид гүүгээ арайхийн сул тавьсан юм. Хамгийн ахмад байгаль хамгаалагч Б.Батсуурийн хамт эхлээд Рэвэта гүүний хайрцгийг нээж, сул тавьсан нь миний хувьд том хүндлэл байлаа.

Дараа өдрийн өглөө нь гүүнүүдийг шалгахад ямар нэгэн гэмтэл, шалбархай болоогүй, аль хэдийнэ эх нутагтаа явж буй мэт тайван амгалан харагдаж байсан юм.

### Баярлахад хэт эрт байв

Прагаас тахийг амжилттай авчирсны дараа ГИДЦГ-ын “Б” бүсэд жижиг хэмжээний баяр хийж тэмдэглэдэг уламжлалтай. Энэ удаад бид Монголын дотоодод дараагийн тээвэрлэлт хийхээр төлөвлөсөн байсан учир цаг зав байсангүй ээ. 7-р сарын 20-нд Булганаас Улаанбаатар хүртэл нисч, тэндээсээ Хустайн БЦГ руу явсан юм.

### Хустайн тахиуд

7-р сарын 21-ны өглөөний 4 цагт бид өглөөний цайгаа уучихаад тахийн хашааруу хөдөллөө. Малын эмч Роман Водичка нойрсуулах тариагаа бэлдчихсэн байсан ба монгол талаас Сайханаа, Өсөхөө нар тахиудийг буудаж тарьсан юм. Тахиудыг нойрсуулах, хайрцаганд хийх ажиллагаа амархан сонсогдож буй боловч гүйцэтгэхэд тийм амар байсангүй. Хашсан байсан тахиуд ажиллагааг хийх үеэр бараг л хашаанаас гараад явчихсангүй, Хустай нэртэй азарга хүчтэй тангарснаас болж тээвэрлэлтийн хуучин хайрцагны хаалга эвдэрсэн ба бид түүнийг илүү бөх хайрцаганд шилжүүлэн хийх шаардлагатай болсон.



*Ховдын Булган суманд Чехийн хөлөг онгоц Каса бууж буй нь. Газардсаны дараа хайрцагийг ачааны машинд ачлаа. Булганаас ГИДЦГ-ын Тахийн Тал хүрэх зам эхний хэсэгтэй засмал замтай. Онгоцны буудлаас цуваа бараг 3 цаг орчим явсны дараа шороон замаар явна.*

*Маргааш өглөө нь нутагшуулах хашаанд явж буй тахь: ядарсан боловч эрүүл саруул харагдаж байна.*



*Хустайн нуруу- хүмүүс сэтгэл хангалуун байна: Долоо хоногийн өмнө дасгах хашаанаас барьсан 4 тахийг тээвэрлэлтийн хайрцганд ачсан байна. Хустайн захирал Цэрэндэлэгийн Дашпүрэв (зүүн гар талын) болон Олон улсын тахь группын Монгол дахь товчооны захирал Намтарын Энхсайхан нар бие биедээ баяр хүргэж байна. Дотоодын тээвэрлэлтээр Хустайгаас Улаанбаатар, тэндээс агаараар Говь руу тээвэрлэх гэж буй нь.*

### Зийгфрийд сангийн үйл ажиллагаа

2016 оны 10-р сарын 30-нд Жэан-Пийррэ болон Соня нар Зийгфрийд сангийн энэ жилийн эхний үйл ажиллагаандаа урьсан юм. Олон улсын тахь группын үйл ажиллагаа болоод тахийг эргэн нутагшуулах талаар сонсож, мэдэх зорилготой 60 орчим хүн цугларсан байлаа. Сангийн үйл ажиллагааг Штэфан, Андрэас нар удирдан явуулдаг ба Тахийг хамгаалах зорилгоор хөрөнгө босгож, үүгээрээ олон улсын тахь группын үйл ажиллагааны ихээхэн хэсгийг санхүүжүүлж, дэмжлэг үзүүлдэг. Эцэг Жэан-Пийррэ Зийгфрийд (†) (зурганд зүүн гар талд) Кристиан Освальд, Очирын Доржраа нарын санаачилсан тахь хамгаалах хөтөлбөрийг дэмжиж, төслийн эхэн үе болох сорилтын үед удирдан, 1999 онд олон улсын тахь группыг байгуулсан юм. Холыг харагч, санхүүжүүлэгч, Кристиан Освальд болон Доротээ Штамм нарын хамтрагчтай энэхүү эрхэм байгаагүй бол олон сорилтыг даван туулж тахийг сэргээн нутагшуулах мөрөөдөл биелэхгүй, говьд тахь сэргээн нутагшуулж чадахгүй байх байсан.



### Төгсгөл

10:40 минутанд бид Хустайн нуруунаас Улаанбаатарын зүг хөдөллөө. Хустай нэртэй азарга болон Арвин, Бэбэ, Фанни гүүнүүдийг ачааны машинд тээвэрлэж явсан юм. Бараг л 100 км газарт 2,5-с илүү цаг зарцуулсан ба Улаанбаатарын ойролцоо биднийг цагдаагийн хамгаалалттай машин хүлээж байв. Азаар онгоцны буудал хүрэх замын хөдөлгөөн тийм ч их байгаагүй ба цагдаагийн хамгаалалтын машин дохиоллоо зарим нэг машин болон зам дээрх үхрээс болж хэд хэдэн удаа дуугаргах шаардлага гарч байлаа.

Тахийг ачиж, утсаар дуудлага хийсний дараа КАСА хөлөг орон нутгийн цагаар 16:15 минутанд хөөрч бараг 3 цаг 30 минутын дараа Булган суманд газардсан юм. Салхи урьдынхаас хүчтэй байсан ч зөвшөөрөгдсөн хэмжээнээс хараахан даваагүй нь бидний аз байв.

Тахиудаа бид дахин ачааны машинд ачиж, ГИДЦГ-ын "Б" хэсэг рүү явах болсон юм. ГИДЦГ-ын зүүн хэсэг буюу Тахийн талд азаргыг аваачсан бол гүүнүүдийг цөөн тахьтай ГИДЦГ-ын баруун хэсэг болох Тахийн усанд аваачсан юм.

7-р сарын 22-нд орон нутгийн цагаар 00:45 минутанд гүүнүүдийг хайрцагнаас гаргасан бол азаргыг 01:45 минутанд тавьсан юм. Бүх тахиуд эрүүл саруул, аяллын ачаалалд ядарсан байв. Ийнхүү бид ажлаа дуусгасны дараа тээвэрлэлтийн баг Тахийн талын хамт олонтой баяраа тэмдэглэсэн.

### Хорин долоо

Олон улсын Тахь Групп болон бусад түншүүдтэй хамтран КАСА цэргийн онгоцоор аюулгүй тээвэрлэж ирсэн тахийн тоо 2011 оноос хойш энэ жил 27 болтлоо нэмэгдсэн. Энэхүү ажлыг үр дүнтэй гүйцэтгэхэд амьтны хүрээлэнгийн амьтан маллагч болоод цэргийн онгоцны нисгэгч, мөн монголын хамт олон зэрэг олон олон хүний хичээл зүтгэл шингэсэн юм. Эдгээр хүмүүсийн хүчин чармайлтгүйгээр тахийг сэргээн нутагшуулах ажил ингэж амжилттай, тогтмол үргэлжлэх боломжгүй байх байсан.

### Говьд нутагшуулж буй тахийн тоо толгой өсөж байна

ГИДЦГ-ын "Б" бүсэд байгаа тахийн сүргийн тоо цөөхөн учир эмзэг. Гэвч энэ жил 173 хүрч шинэ рекорд тогтоолоо. Энэхүү тахиуд нь 15 орчим тооны азарган сүрэгт зуваагдан нутагшиж байгаа бөгөөд сүргийн тоо нь тухайн азарганы нас, хүч чадлаас хамааран харилцан адилгүй байдаг. Энэ жилийн хавар 50 орчим гүү хээлтэй байсан ба найдаж байсны дагуу сүрэг өсөж, 126 толгойгоос харьцангуй сайн өссөн жил байлаа. Одоогоор тахийн сүргүүдийн шилжилт хөдөлгөөн ихсэх, газар нутгаа тэлэх зэрэг зан төрхийн шинж чанарууд нь байгалийн популяцийн онцлогийг харуулж буй хэрэг бөгөөд бид их баяртай байна. Зөвхөн ийм байдлаар л амьдрах ур чадварууд дамжин өвлөгдөнө. Үүнийг дагаад гэршүүлсэн адуун сүрэгтэй нийлэх эрсдэл ихэсч байна. Энэ нь өвчин авах, эрлийзжих зэрэг сөрөг үр дагавартай боловч энэ нь манай хамгаалагчдын харьцангуй сайн хяналтанд байгаа.

## Бүхий л шатанд холбоо тогтоон цаашид хамтарч хийгдэх ажил их байна

Олон улсын Тахь Группын ерөнхийлөгч ноён Райнхард Шнидрих болон хатагтай Мириам Вурш нар 10-р сард нэлээд их ажил төлөвлөн Монголд ажилласан юм. Монголын улс төрд МАН ялсан учир аймаг, сумдын засаг захиргааныхан болон Байгаль орчны яамны шинэ удирдлагуудтай уулзан, Олон улсын тахь группын зорилго, зорилт болоод хүсэлтийг танилцуулах зорилготой байсан. Мөн түүнчлэн МУ-ын ерөнхийлөгч болоод Монгол улсын их сургуулийн биологийн факультет, монголын аялал жуулчлалын агентлаг, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай тогтоосон харилцаагаа дахин сэргээж, ойрын зорилгуудынхаа талаар хэлэлцсэн юм.

Орон нутаг, аймгийн засаг захиргаа болоод байгаль орчны яамны сайд Дуламсүрэнгийн Оюунхорол нар тахь группын төлөөлөгчдийн санал бодлыг нээлттэй хүлээн авч байсан. Олон улсын тахь групп нь Монгол улсад улс төр, нам үл харгалзан хамтран ажиллах, дэмжлэг авч ажилладаг бөгөөд МУ-ын ерөнхийлөгч биднийг хүлээн авч уулзсанд бид маш их баяртай байна. Тэрээр олон улсын тахь группын үйл ажиллагааг бүхий л шатанд дэмжихээ илэрхийлсэн. Байгаль орчны сайд хатагтай Д.Оюунхорол ГИДЦГазрын хилийн бүсийг өргөтгөх, хамгаалалттай нутгийг томруулах талаар УИХ-д авч хэлэлцүүлэхээр төлөвлөж байгаа юм. Монгол, Хятадын хооронд нүүдэллэн амьдардаг амьтдад нүүдэллэх зам харгуйг дахин сэргээх, гаргах санааг эерэгээр хүлээн авч байлаа.

Швейцарийн Хөгжлийн Агентлаг, Германы Олон Улсын Хамтын Ажиллагаа, Германы Сэргээн босголтын банкныхантай хийсэн уулзалтуудаас тусгай хамгаалалтын газруудад коридор үүсгэх, амьтдын нүүдэллэх замыг дахин сэргээх ажлаа хэрхэн санхүүжүүлэх боломжийн талаар нэлээд үнэ цэнэтэй мэдээлэл авсан юм. Монголын өмнөд хэсгээр хийсэн аяллаар бид нүүдлийн зам гаргах боломжтойг, өөрөөр хэлбэл тулгарч буй саад бэрхшээлийг олж харсан юм. Төлөөлөгчид ГИДЦГ-ийн "Б" бүстэй экологийн хувьд холбогдсон Их Говийн "А" бүстэй холбоо тогтоосон. Монголын баруун урд байрлах ГИДЦГ-ын цаашдын хэтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд хамтын стратеги чухал юм.

### Хэтийн төлөвлөгөөндөө алхам алхмаар

2017 онд „Тахийг Говьд сэргээн нутагшуулсны 25 жилийн ой“ тохиох юм. Энэ ажилд олон хүний хүч хөдөлмөр, сэтгэл зүрх шингэсэн. Энэхүү ойн хүрээнд Монголд олон үйл ажиллагааг хийхээр төлөвлөөд байна:

- Монголын алдарт хамтлаг „Хурд“-тай хамтран „Буцаж ирсэн бурхны адуу“ дууг бүтээж, олон нийтийн хүртээл болгоно.
- Блю Мүүн уран зургийн галерейд өнгөрсөн 25 жилийн турш тахь нутагшуулах ажиллагааг харуулсан гэрэл зургийн үзэсгэлэнг 4-р сарын 14-нөөс 20-ны хооронд олон нийтэд толилуулна.
- Тахь нутагшуулах төслийг сурталчлан, дэмжигч санхүүжүүлэгч, спонсоруудын дунд хүлээн авалт зохион байгуулна.
- Хятадын тахь хамгаалагчдыг оролцуулан Тахийн талд сургалт зохион байгуулахаас гадна ойн ёслолын үйл ажиллагаа зохион байгуулна. Энэ нь хоёр улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн, дээшлүүлэх зорилготой.



Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд, Дуламсүрэнгийн Оюунхорол (голд) Олон улсын тахь группын төлөөлөгчид (зүүн гар талаас Намтарын Энхсайхан, Мириам Вурш, Райнхард Шнидрих болон Очирын Доржраа)-ийг хүлээн авч, Олон улсын тахь групптэй хамтран ажиллах олон зүйлд амлалт өгсөн юм.

Говийн төрөл зүйлийг судлах, мониторинг хийх ажил 2017 оны хувьд чухал сэдэв хэвээр байх болно. Түүнчлэн геологийн, дэлгэрэнгүй болоод олон талт мэдээлэл бүхий газрын зургийн тусламжтай нүүдлийн замыг хамгаалах, экологийн хувьд холбох асуудлыг тодорхой болгох юм. Энэ нь монголын засгийн газартай хамтран ГИДЦГ-ын "Б" бүсийн газар нутгийг менежментийн хувьд төлөвлөх шинэ ажлын нэг хэсэг юм. Райнхард Шнидрих Тахийн талд очих үеэрээ ГИДЦГ-ын "Б" бүсийн захирал болоод бусад талуудын төлөөлөгчидтэй уулзалт хийсэн.

### Тахийн тал дах ус!

ГИДЦГ-ын "Б" хамгаалалтын захиргааны төв буюу тахь нутагшуулах төв нь жуулчид, зочдод зориулсан цөөн гэрүүд, захиргааны байр, ажилчдын гэрүүдээс бүрдэх бөгөөд өнөөдрийг хүртэл ундны усны асуудал шийдэгдээгүй зөөврийн устай байсан. Төвийн усны асуудал нь Олон улсын тахь группын санхүүгийн чадамжаас хэтэрсэн асуудал байсан ба энэ нөхцөл байдлыг Прагийн амьтны хүрээлэнгийн санаачлага, Чехийн хөгжлийн хамтын ажиллагаа, ЭСЯ-ны тусламжаар худаг гаргаж шийдэж өглөө. Ийнхүү Тахийн талд амьдарч буй тахь хамгаалагчдын амьдрал илүү хялбар болохоос гадна тус нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхэд таатай нөхцөл бүрдсэн юм.



Үргэлжлэл 7-р хуудсанд

Говь нутгийн ил задгай болон худгийн ус нь давс, хатуулаг ихтэй байдаг ч азаар бидний худаг газрын гүний 140 метрээс гарсан тул хүний ундны усны стандартын шаардлагад нийцсэн сайн чанарын ус байгаа нь сайн хэрэг юм.



*Тахийн тал устай боллоо! Дархан газрын хамт олон болон худгийн өрөмдлөгийн багийнхан ихэд баяртай байна.*

### Хар сүүлт зээр

Зүүнгарын говь эх газрын хуурай нутаг дэвсгэрт байрлахаас гадна цаг уурын эрс тэс уур амьсгалтай учир өвсөн тэжээлт амьтдаас цөөн төрөл зүйл амьдардаг. Энд тахь, хулангаас гадна хар сүүлт зээр элбэг тархан нутагладаг. Биеийн хэмжээгээр бор гөрөөстэй ойролцоо, 20-30 кг жинтэй, шаргал өнгөтэй, гэдсэн хэсгээрээ цагаан, нүүрэн хэсэгтээ бараавтар судалтай энэхүү зээрийг түүний тархалтаас 2000 гаруй км алслагдсан тархалттай Персийн хар сүүлт зээр (Латин нэр нь *Gazella subgutturosa*) –ийн дэд зүйл гэж хэлдэг үздэг байв.

Гэвч сүүл үеийн судалгаагаар монголд тархалттай хар сүүлтий зээр нь магадгүй өөрийн онцлог, тархалт, монотип байдлаараа "Ярканд зээр (*Gazella yarkandensis*)"<sup>1</sup> байж болох өвөрмөц дүгнэлт гарч ирээд байгаа юм.

Энэ зүйл зээр нь Хятадын баруун хойно, хойд хэсгийн буюу тал нутаг, говь тал нутаг болон Монголд нутаглан амьдардаг ба говийн өвс ургамал болох загны мөчир, нийлмэл цэцэгтэн, шарилж, хөмүүл, давслаг ургамлаар хооллодог. Тэд ойролцоогоор 10 орчим толгойгоор сүрэлгэх ба өвөлдөө илүү 20-30 хүртэл олуулаа болдог. Энэхүү зүйл нь IUCN –с гаргадаг "аюулд өртсөн" гэсэн ангилалд бичигдээгүй ба энэ талаарх мэдээлэл байхгүй болно. Ямартаа ч бидний мэдэх хар сүүлт зээр *Gazella subgutturosa* болон Ярканд зээр *Gazella yarkandensis*-ийн зүйлүүд нь ангилалзүйн хувьд нэлээд ойролцоо, маргаантай дэд зүйлүүд бололтой.

Олон улсын байгаль хамгаалах холбооны үнэлгээгээр дэлхий дээр эдгээр зүйл зээрүүд нь амьдрах орчны доройтол, хууль бус агнуураас үүдэн тоо толгой нь нэлээд багассан бөгөөд Монголд энэ зүйл зээрийн популяцийн цөм хэсэг нь тархсан. Мөн дээрхтэй ижил шалтгаанаар тоо толгой нь 50 хүртэлх хувиар багассан мэдээ байдаг.

<sup>1</sup> Lynx Edicions, Дэлхийн хөхтөн амьтны гарын авлага, 2011, 639 тал



## Олон улсын тахь групп нь засаг, захиргаанд тусалдаг

Хэдийгээр бидний үйл ажиллагааны зорилго нь тахийн амьдрах орчин, говийн экосистемийг хамгаалахад орших боловч Олон улсын тахь групп нь орон нутгийн ард иргэдэд туслах, тэдэнд хэрэгтэй үйл ажиллагааг дэмждэг. Манай удирдах зөвлөлийн гишүүн Анита Фарни өнгөрсөн зун Бугат сумын 70 жилийн ойн баяр наадамд уригдан оролцсон бөгөөд монголын уламжлалт эрийн гурван надам буюу бөх барилдах, нум сум харвах, хурдан морины уралдааныг үзэж сонирхон хурдан морины азарганы уралдааны ивээн тэтгэж шагнал гардуулсан юм. Анита Фарни Монголд ажлын шугамаар 20 гаруй удаа зочилж ажилласан ба Монголын ахуй, нийгэм улс төрийн байдлыг сайн мэдэх хүний нэг юм. Тэрээр Бугат сумын захиргаа болон сургуульд тэдний үйл ажиллагааг дэмжин хүмүүнлэгийн тусламжийг үзүүлэхэд ихээхэн чармайлт гарган ажилласан бөгөөд сумын байгаль орчны тасгийг тохижуулахад зориулан компьютер, техник төхөөрөмж болоод бусад хэрэгслэлийг гардуулан өглөө. Тэрээр ГИДЦГ-ын "Б" бүс болон Тахийн талд зочлон очсон ба ихэд урам зориг дүүрэн байв.

*„Энэ зун бороо их орсон учир гайхмаар олон төрлийн ургамлууд ургасан. Эдгээр ургамал, чулуулагуудын олон сайхан өнгөнийг ялгаж, ойлгохын тулд ботаникч, геологич байх хэрэгтэй болов уу. Говийн өргөн сайхан нутагт чөлөөтэй бэлчиж байгаа тахийн сүргийг харснаар байгаль орчинд хүндэтгэлтэй хандах ба түүнийг хамгаалах тэмүүлэл минь ихээр нэмэгдлээ. Энэхүү нам гүм, алс газар нутагт олон өдрөөр зочлоосой гэж би халуун сэтгэлээсээ зөвлөж байна. Элдэг үйлчилгээ үзүүлдэг энэ төв нь байгальд дурлагсадын хувьд хамгийн тохиромжтой газар бөгөөд сургалт, судалгаа, хайгуулын багт шаардагдах суурь бааз байж болно.“*

Анита Монголд энэ удаа ирэхээсээ өмнө Бугатын хүүхдүүд болон тахийн талын байгаль хамгаалагчдад англи хэл заалгахаар сайн дурын ажилтан багш Ули Рутцийг урьж ирүүлсэн юм. Тахийн талд ноён Рутц 5-р сарын дундаас 6-р сарын дунд хүртэл байсан ба Тахийн талд барьж буй тахийн хашаа барих ажил болон тахийн сүргийг ажиглах ажилд тусалж байсан юм. Та тахийн мэдээний дараагийн дугаараас энэ талаар дэлгэрэнгүй уншаарай.



*Анита Фарни наадмаар хурдан морьны уралдаанд айрагдсан уяачдад шагналыг нь гардуулж буй нь.*

## Таны тусламж бидэнд хэрэгтэй

Байгаль орчныг хамгаалах ажил нь тийм ч дуулиантай боловч дадал болсон ар талын ажлыг амжилттай төсөл болгоход тийм ч амаргүй юм.

Тиймээс таны өгсөн тусламжаар хэр олон зүйлд өөрчлөлт авчрахыг та эндээс харна уу. Өгч буй хандив бүр бидэнд үнэ цэнэтэй ба нээлттэй хүлээн авах болно.



### 40000 төгрөг

Хамгаалагчийн нэг өдрийн хөлс (цалин, материалын зардал)



### 120000 төгрөг

Унааны шатахууны зардал.



### 200000 төгрөг

Байгаль хамгаалагчдын машины засвар, сэлбэг.



### 300000 төгрөг

Монгол-хятадын байгаль хамгаалагчдын хамтарсан ахны сургалтанд хандив болно



### 500000 төгрөг

Байгаль хамгаалагчийн нэг сарын унааны зардал



### 1000000 төгрөг

Тайхын сүргүүдийн нэг өвөлд зориулсан өвсөн тэжээл

## Олон улсын тахь групп нь сайн дурын үндсэн дээр ажилладаг ба таны хандивласан төгрөг бүр тахь хамгаалахад зориулагдана.

“Тайхын нөхөд”-ийн гишүүн болох боломж байна.

- Хувь хүний татвар 100000 төгрөг

- Оюутан, залууст зориулсан унага – гишүүний татвар 20000 төгрөг

### Хандивын данс

Худалдаа Хөгжлийн Банк

Дансны дугаар: 499114883 ам доллар  
499248691 төгрөг

Тайхын нөхөд сан  
Байгаль Ордон  
Улаанбаатар-38  
Монгол улс

### Эрхлэн гаргасан

Олон улсын тахь групп  
Тайхын нөхөд  
Цюрих Вилдниспарк сан  
Алтэ Зийлтал гудамж 38  
CH-8135 Зийлвалд / Цюрих  
www.savethewildhorse.org  
info@savethewildhorse.org



ITG INTERNATIONAL TAKHI-GROUP

Байгаль орчинд ээлтэй цаасан дээр хэвлэв  
(Novatech Satin halb matt FSC)

